

ЦАХИЛГААН ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ



**Стандарт 10. Багшлах
бүрэлдэхүүний заах аргын
чадамжийг сайжруулах**

CDIO –г хэрэгжүүлэхээс өмнөх үйл ажиллагаа

Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт заах арга зүйг дээшлүүлэх талд үр өгөөж муутай байсан

CDIO- г хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа

3 жилийн хугацаанд CDIO загварын 12 стандартыг хэрхэн эзэмшүүлэх, хэрэгжүүлэх талаар маш олон сургалтууд зохион байгуулсан.

Цаашид хийгдэх ажил

Цаашид сургуулийн бүх багш нарыг хамруулан сургалт хийх, ахисан түвшний сургалтууд зохион байгуулах

Голлох үр өгөөж, үр дүн

Салбарын багш нар CDIO загварын дагуу хичээл төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх чадвартай болсон

Хэрэгжүүлэх явцад илэрсэн давуу болон сул тал

Давуу тал:

- Багш нарын чадвар

Сул тал:

- Заах арга зүй, үнэлгээ талд илүү чадваржуулах



Үйл ажиллагааны нотолгоо



Багшийн чадавхи

Профессор, багшийн ажлын ачаалал

ШУТИС-ийн ректорын 2015 оны 02 сарын 05-ны өдрийн А/23 тоот тушаалаар батлагдсан “Багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ын дагуу багш нарын ажлын ачааллыг тодорхойлж, хуваарилалт хийдэг. Энэхүү журамд зааснаар профессор багш нарын хөдөлмөр нь их сургуулийн 3 үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд: ажлын

- Сургалт(А цаг)
- Эрдэм шинжилгээ, инноваци(Б цаг)
- Сургууль, олон нийтийн үйл ажиллагаа(В цаг)

Нэг хичээлийн жилд профессор, багшийн ажлын ноогдол 20 кредит байх ба тэдгээрийн албан тушаалаас хамаарч харьцаа нь ялгаатай байна. Хүснэгт 8.3-аас профессор, багшийн А, Б, В цагийн ноогдолын харьцааг харж болно. Жишээ нь профессорын албан тушаалд ажиллаж байгаа багшийн сургалтын ажлын ачаалал 10 кредит, судалгаа шинжилгээний ажлын ачаалал 6 кредит, олон нийт, үйлчилгээний ажлын ачаалал 4 кредит байх ба нийт ачаалал нь 20 кредит буюу 960 цаг байна.

Багшийн хангамж:

Салбарын хэмжээнд нийт 33 профессор багш ажиллаж байгаагаас ЦХИТ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 27 багш оролцож байна. Хүснэгт 4.2-д үзүүлснээр эдгээр багш нар нь бүгд магистр ба түүнээс дээш зэрэг цолтойгоос гадна утасгүй холбоо, цахилгаан холбооны чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлийн хичээлүүдийг олон жил заасан дадлага туршлагтай.

Гаднаас цагийн багш авахгүйгээр ЦХИТ хөтөлбөр болон бусад салбарын хөтөлбөрүүдэд байгаа салбарын хичээлүүдийг заах үндсэн багшийн хангалттай нөөцтэй.

Багш нарын мэргэжил дээшлүүлэлт (1)

Багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа үндсэн 2 чиглэлээр явагддаг. Үүнд:

- Багш нарын сурган, заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх
- Багш нарын мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх

Багш нарын сурган, заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх: Шинээр ажилд орж байгаа багш нар ихэвчлэн инженер технологийн мэргэжилтэй, сурган заах арга зүйн талд туршлага багатай байдаг учраас ШУТИС-ийн багшийн хөгжлийн төв болон дээд боловсрол судлалын төвөөс сурган заах, арга зүйн сургалтыг зохион байгуулж багшлах эрхийн гэрчилгээ(сертификат) олгодог.

Багш нарын мэргэжил дээшлүүлэлт (2)

Мөн ШУТИС-д 2014 оноос эхлэн олон улсын инженерийн боловсролын CDIO стандарт, арга зүйг нэвтрүүлж байгаатай холбоотой сургалтын шинэ стандарт, арга зүйн талаар цуврал сургалт зохион байгуулж байна. Тухайлбал 2015 онд Сингапурын TEMASEK сан, Сингапурын Политехникийн сургууль болон Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яам хамтран ШУТИС, МУИС, ХААИС-ийн 160 гаруй багш нарт 5 удаагийн цуврал сургалт зохион байгуулахад тус салбарын 5 багш хамрагдаж сурган заах арга зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. Эдгээр 5 багш сургуулийн болон салбарын багш нарт үр дүнд суурилсан боловсрол, CDIO стандарт арга зүйн талаар 10 гаруй удаа сургалт зохион байгуулсан. Мөн сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж байгаа шинэлэг, арга туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хуваалцах, бусдаас суралцах үүднээс боловсролын чиглэлийн эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх талд салбарын багш нар идэвхитэй ажиллаж байна.

Багш нарын нарын мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх

- Их сургуулийн багш заавал судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж докторын зэрэг хамгаалсан байх ёстой учраас шинээр ажилд орсон магистр зэрэгтэй багш нар ШУТИС-ийн болон гадаадын их дээд сургуулийн докторын сургалтанд элсэн суралцдаг. 2017 оны байдлаар тус салбарын 8 багш ШУТИС-д, 2 багш Япон улсад докторын сургалтанд суралцаж байгаа бол 4 багш Солонгос улсын их дээд сургуулиудад докторын зэрэг хамгаалаад байна. Мөн тус салбарын 10 багш Энэтхэг улсын SAC, ISRO-д “Сансрын холбоо”, “Хиймэл дагуулын навигацийн систем”-ийн чиглэлийн 9 сарын хугацаатай магистрын түвшний сургалтанд хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн байна.
- ЦХИТ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багш нар дотоодын байгууллага, компаниудын захиалгаар гэрээт ажил, төсөл гүйцэтгэх, олон улсын хурлуудад илтгэл хэлэлцүүлэх, IEEE индекстэй, өндөр чансаатай сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэх замаар багш нарыхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна.

Багшлах бүрэлдэхүүний эрх, үүрэг

- ЦХИТ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа салбарын бүх багш нар сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн боловсролын зорилго зорилтууд, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд, хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийг шинэчилэх, сайжруулах үйл явцад оролцох эрхтэй. Эдгээр шинэчлэл, сайжруулалтууд нь ерөнхийдээ шууд бус үнэлгээ буюу санал асуулгууд, шууд үнэлгээ буюу суралцахуйн үр дүнгүүдийн гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлах бөгөөд хөтөлбөрийн мэргэжлийн зөвлөл болон салбар, сургууль, их сургуулийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцэгдэн баталгааждаг.
- Багш нарын хувьд тухайн улиралд заасан хичээл бүрээр суралцахуйн үр дүнгийн үнэлгээний тайлан гаргаж, хичээлийн аль үр дүнгүүд зорилтот түвшинд хүрсэн, аль үр дүнгүүд зорилтот түвшинд хүрээгүйг тодорхойлон дараагийн улиралд хэрхэн сайжруулах төлөвлөгөө гаргаж салбарын Сургалтын хөтөлбөр хариуцсан дэд зөвлөлөөр(СХХДЗ) хэлэлцүүлж баталгаажуулдаг уламжлалтай.